

ТАХИЙН МЭДЭЭ



ITG INTERNATIONAL TAKHI-GROUP



№. 6 | 2017 оны 4-р сар

МОНГОЛЫН ГОВЬ НУТГИЙГ ОЙЛГОХУЙ.

Говийн Их Дархан Цаазат Газар (ГИДЦГ)-ын “Б” бүс нь тахь адуу, одой заг гэх мэт дэлхийд ховор амьтан, ургамлын өлгий төдийгүй нутгийн нүүдэлч малчид эрт үеэс эдүгэ хүртэл ашиглан нутаглаж ирсэн өвөрмөц нутаг юм. Говь тал нутгийн энэхүү экосистемийг цогцоор хамгаалах талаарх олон асуудлуудыг шийдэх шаардлага байсаар л байна.

**Тахь болон түүний амьдрах орчинг
хамтдаа хамгаалцгаая**

**ТАХИЙГ СЭРГЭЭН
НУТАГШУУЛСНЫ
25 ЖИЛИЙН ОЙД**

Тахийг хайрлан хамгаалдаг эрхэм андууд аа!



Энэ жил Монгол тахь эх нутагтаа эргэн ирсний 25 жилийн ой тохиож байна! Энэхүү 25 жилд тахийг эх нутагт нь сэргээн нутагшуулах нь Олон Улсын Тахь Группын үндсэн үйл ажиллагаа байсан юм. Тахь байгальд зэрлэгээрээ үзэгдэхээ больж устсан бөгөөд гаршуулсан нөхцөлд тоо толгой болон удмын сан нь харьцангуй доройтсон үед эх нутагт нь амжилттай сэргээн нутагшуулж чадсан нь байгаль орчныг хамгаалахад оруулсан маш том хувь нэмэр болсон бөгөөд энэхүү буянт үйл ажиллагааг дэмжин ажилласан та бүхэн бидэнтэй хамт амжилтаараа бахархах нь зүйн хэрэг юм.

Говь нутгийн экосистемийн онцлог зохилдолгоо, зүй тогтлыг ойлгох, баримтжуулах нь бидний хувьд аливаа нэг төрөл зүйлийг хамгаалахаас ч илүү чухал юм. Тийм ч учраас өнгөрсөн хугацаанд манай амьтан судлаачид болон байгаль хамгаалагч нар төв азийн хүйтэн сэрүүн бүс нутгийн экологийг судлахад ихэд анхаарлаа хандуулж ирсэн. Маш олон цагийг нар, салхи, байгалийн цаг уурын хүнд нөхцлүүдийг үл ажран шинжлэх ухааны аргачлалаар тэвчээртэй ажиглалт, судалгааг хийж ирсэн. Манай байгаль хамгаалагч нар сэргээн нутагшуулж байгаа тахиудыг нэг бүрчлэн зүслэн таньж, нэрлэж чаддаг гэдэгт та итгэх үү? Экосистемийг судлах, хамгаалахад тэдний дадлага чадвар, энэ их хичээл зүтгэл маш чухал үүрэгтэй байдаг.

Говьд тахийг сэргээн нутагшуулах төсөл хэрэгжиснээр тахийг хэрхэн мэдээ алдуулах, аюулгүй тээвэрлэх, суллан тавихад шаардагдах сүргийн бүтэц, зохион байгуулалт, зан төрх, идэш

тэжээлийн экологи, орон зайн ашиглалт, үржлийн биологийн онцлог болон өвчлөлт, паразит гэх мэт урьд өмнө нь хийгдэж байгаагүй олон судалгааны ажлууд хийгждээ. Мөн тухайн экосистемийн бусад төрөл зүйл болох хулан, саарал чоно, олон зүйл мэрэгчид, махчин шувуудын судалгаа, нутгийн нүүдэлч малчид, тэдний мал сүрэг хамгаалалттай нутгийн бэлчээр усыг улирлын чанартай хэрхэн ашигладаг зэргийг зохих түвшинд тодорхойлон судалсан байна. Түүнчлэн ГИДЦГ-ын Б хэсгийн ургамалжилтын газрын зургийг гаргаж анх удаа дижитал хэлбэрт оруулсан юм.

Гэсэн хэдийч энэхүү говийн экосистемийн судалгааны асуудлууд зарим анхан шатны хариултаа хүлээсээр л байна. Тодруулбал хамгаалалттай нутгийн баян бүрд уст цэгүүдийг зэрлэг амьтад болон мал улирлын чанартай хэрхэн ашигладаг, усны чанар нь ямар болох, бэлчээр нутгийг өөр хоорондоо хэрхэн зохицож эзэмшдэг, хар сүүлт зээрийн амьдрлын онцлог, төв азийн хүйтэн сэрүүн бүсийн тал нутагт цаг уурын өөрчлөлт хэрхэн нөлөөлж буй зэрэг олон асуудал шийдэгдээгүй байна.

Эдгээр олон асуудлыг шийдэхийн тулд хамгаалалттай нутгийн экосистемийг цогцоор нь судлах шаардлагатай ба орон нутгийн ард иргэдийг үүнд орхигдуулж болохгүй юм. Иймд бид судалгаа шинжилгээний ажлуудыг идэвхтэй үргэлжлүүлж, цаашид системчилэн явуулах шаардлагатай. Идэвхи зүтгэл сайтай эрдэмтэд, тэдний бий болгосон дэд бүтэц нь төслийг бүхэлд нь хөгжүүлэхэд маш их хувь нэмэр оруулсан, оруулсаар байна. Тийм ч учраас бид санаачлагтайгаар хамтран ажилласаар байна. Шийдэл олоход та бидэнд туслаарай.

Д-р. Райнхард Шнидрих,
Олон Улсын Тахь Группын ерөнхийлөгч



ТАХЬ НУТАГТАА ЭРГЭН ИРСНИЙ 25 ЖИЛИЙН ОЙ



Хүн төрөлхтний түүхийг та морьгүйгээр төсөөлж чадах уу? Төсөөлшгүй. Монголын түүх, цэрэг эрсийг морьгүйгээр төсөөлж байна уу? Мөн адил төсөөлөхийн аргагүй. Хэдийгээр тийм ч гэрийн адууны өвөг эцэг устаж, өнөөдрийг хүртэл зэрлэг адууны зөвхөн нэг төрөл зүйл үлдсэн нь ТАХЬ юм. Тахийг устахаас нь өмнө хамгаалах ажлыг шийдэмгий, холын хараатай хэсэг буянтны ачаар хэрэгжүүлсэн. Гэвч бидний түүх, соёлын эх сурвалж болсон хамгийн чухал зүйлс устаж үгүй болсон нь тун харамсалтай.

Тахь нь зөвхөн монголчууд төдийгүй хүн төрөлхтөний өв гэдгийг бид өнөөдөр илүү сайн ойлгосон байх. Говь нутгийн онцлог байхгүйгээр говь гэж байхгүйтэй адил монголчуудын хувьд энэхүү хийморлог, зэрлэг адуу нь тасралтгүй үргэлжлэх “Тал нутгийн илэрхийлэл” юм. Тахийн хувь заяа 30 жилийн өмнө тодорхой бус байсан хэдий ч одоогоос 25 жилийн өмнөөс – нэгэн үе – тахь өөрийн эх орондоо давхих болсон юм. Энэ нь хүн төрөлхтний бэлэг ба аливаа төрөл зүйл хэрхэн хурдан устаж үгүй болдог, сүүлийн мөчид эргэн сэргээн нутагшуулахад хэр их зардал гардаг болохыг харуулсан анхааруулга байлаа.

ГИДЦГ-ын „Б” хэсэгт тахь сэргээн нутагшуулсны 25 жилийн ой энэ жил тохиож байгаа бөгөөд Монгол Швейцарь улс байгаль хамгаалах болон ховор амьтан хамгаалах салбарт амжилттай хамтран ажиллаж байгааг харуулсан түүхэн ач холбогдолтой үйл ажиллагаа юм. Энэхүү хамтын ажиллагааны үр дүнг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлуудыг Швейцарийн хөгжлийн агентлаг санхүүжүүлэн ажиллаж байгаад баяртай байна. Ойд зориулж монголын өргөн уудам тал нутагт тахь эргэн ирснийг санагдуулахуйц нэгэн гайхалтай аялгууг монголын алдарт ХУРД хамтлаг зохиосон. Улаанбаатар хот дахь “Чингэс шар айраг” ХХК-ийн захирал, Олон улсын тахь группын идэвхтэй гишүүн ноён Алфрэд Нэйф гуай Говь-Алтай аймгийн ахмад сэтгүүч Д.Лхагвасүрэнгийн “Буцаж ирсэн бурхны адуу” шүлгийг сонгон энэхүү дууны захиалгыг өгч, бүтээлгэсэн юм.

Мөн энэхүү ойг тэмдэглэх ажлын хүрээнд Зүүнгарын говьд нутагшуулж байгаа тахийн сүргийн талаарх гэрэл зургийн үзэсгэлэнг Улаанбаатар хотын Блю Моон уран зургийн галерейд 2017 оны 04-р сарын 15-20-ны хооронд зохион байгуулахаар төлөвлөж байна. Тахь эргэн нутагшуулсан үйл ажиллагааны талаарх видео, Тахийн талын байгаль хамгаалах 25 жилийн үйл ажиллагааны талаарх шилдэг гэрэл зургуудын үзэсгэлэнгээр энэхүү онцгой өвийг залуу хойч үедээ үлдээхийн ач холбогдлыг харуулах юм. 4-р сарын 14 өдрийн 17:00 цагт болох нээлтэнд МУ-ын Байгаль орчин, аялал жуулчлалын сайд хатагтай Д.Оюунхорол, Швейцарийн хөгжлийн агентлаг ерөнхий консул хатагтай Габрийла Шпирли нар үг хэлж, мэндчилнэ. Энэхүү гэрэл зургийн үзэсгэлэнг орон нутагт шилжүүлэн үзүүлэх ба зургийг сонирхсон хүн худалдан авч болно. Цугларсан орлогыг тахь нутагшуулах төвийн байрны сантехникийн холболтын зардалд зориулахаар төлөвлөж байна. Blue Moon галерей 08:00-23:00 цаг хүртэл нээлттэй байна.

Гэрэл зургийн үзэсгэлэн

ГИДЦГ-ын “Б” бүсэд тахь эргэн нутагшуулсны 25 жилийн ойд зориулав

Blue Moon Gallery (Blue Mon Center)

Нээлт: 2017.04.14, Баасан, 17:00 цагт

Нээлтийн мэндчилгээ: Байгаль орчин, аялал жуулчлалын сайд хатагтай Д.Оюунхорол, Швейцарийн хөгжлийн агентлаг ерөнхий консул хатагтай Габрийла Шпирли нар үг хэлж, мэндчилнэ.

Үзэсгэлэн: 2017.04.15-20-ныг хүртэл

Өдөр бүр: 08:00-23:00 цагт

Дуртай ажлаа хийж байхад хэзээ ч хэцүү санагддаггүй!

Байгаль хамгаалагчийн ярилцлага: Ахмад байгаль хамгаалагч Г.Нисэхүү

Сурвалжлагч: Мирям Вурш,
(Олон улсын Тахь Группын удирдах зөвлөлийн гишүүн)

Ахмад байгаль хамгаалагч Нисэхүү (52 настай) 1994 оноос хойш ГИДЦГ-ын "Б" бүсэд ажиллаж байна. Дархан цаазат газрын баруун хэсэг болон Тахийн Ус орчмын тахийн сүргүүдийг хариуцан ажилладаг.

ОУТГ: ГИДЦГ-ын "Б" бүсийн баруун хэсгийг хариуцан ажилладаг ахмад байгаль хамгаалагчийн хувьд таны ажлын нэг өдөр яаж өрнөдөг вэ?

Нисэхүү: Надад хариуцсан үндсэн 2 үүрэгт ажил бий. Эхнийх нь байгаль хамгаалах, өөрөөр хэлбэл хамгаалалттай нутгийн хариуцсан газраа хулгайн анчин эсвэл алтны нинжа нараас хамгаалан сахиу. Хамгаалалтын бүсэд гарсан зөрчлийг мэдээлж, экологийн хувьд үүссэн хохиролд үнэлэлт өгч, тэдэнд хамгаалалтын бүсийн дүрэм, журмыг тайлбарлан өгдөг. Тэгээд тэднийг хамгаалалтын бүсээс гарган, мэдээллээ хуулийн байгууллагад хүргэн зөрчлийг арилгадаг.

Дараагийн үүрэгт ажил нь Тахь! Хамгаалалтын бүсэд долоо хоногт 2-3 удаа явж, заримдаа тэндээ хоноглодог. Харагдаж байгаа тахь бүрийг жагсаан бичиж, тэдний зан авир, амьдрах орчин болон сүргийн бүтцийг тэмдэглэн авдаг. Ялангуяа хавар сүрэгт нэлээн хөдөлгөөн ордог болохоор бүх л үйл явцыг анхааралтай ажиглах хэрэгтэй болдог. Ингэж тэмдэглэсэн тэмдэглэлээ орлогч дарга „Ааги” – Алтансүхэд өгдөг. Алтансүх үнэлгээ гаргадаг. Ингэсний дараа хамгаалалтын бүсийн захирал О. Ганбаатар мэдээллийг цуглуулж улмаар олон улсын тахь групп, судлаачид болон яаманд хүргүүлдэг.

ОУТГ: Өвөлдөө -30°C, зуны халуунд эсвэл ялаа шумуул, хөх түрүү ихсэх хавар цагт цаг наргүй, улирал үл харгалзан талд давхина гэдэг нэлээн хүнд ажил!

Нисэхүү: Хүнд биш, огт хэцүү санагддаггүй! Би тахид хайртай. Дуртай ажлаа хийж байхад хэзээ ч хэцүү санагддаггүй! Би ажилдаа дуртай, ийм чухал үүргийг гүйцэтгэж байгаа ГИДЦГ-ын "Б" бүсийн хамт олон, тахь группын багийн гишүүн гэдгээрээ бахархдаг.

ОУТГ: Та анх яагаад байгаль хамгаалагч болсон юм бэ?

Нисэхүү: Ерөнхий боловсролын сургуулиа төгсөөд би их сургуульд оролгүй цэрэгт явахад шийдсэн юм. Манай гэр бүл дуу, хөгжим их сонирхдог байсан учир би армийн хөгжимчин болсон юм. Цэргийн албанд 3 жил алба хашсаны дараа намайг армидаа үлдэхийг санал болгоод, би хөгжимчин, дууны багшаар үлдсэн. 1989 онд Монголд улс төр, нийгмийн тогтолцоо өөрчлөгдөж, эдийн засгийн хүнд нөхцөл байдал үүссэн цаг үед ажил олоход их хэцүү байсан. Тэгэхэд манай ээж аав намайг Алтай (Ховд аймаг) руу гэртээ ирэхийг зөвлөсөн. Тэгээд би гэртээ ирж мал маллаж эхлэсэн бөгөөд нутаг орон байгальдаа ойрхон байсан болохоор сайн дураараа байгаль хамгаалах ажилд тусладаг байсан. 1994 оноос ГИДЦГ-ын "Б" бүсэд байгаль хамгаалагчаар ажиллаж байна. Нийт 34 жил улсад ажилласнаас 22 жил нь улсын тусгай хамгаалалттай газар ажиллаж байна.

ОУТГ: Би таныг лимбэ дарж, дуулдаг гэж сонслоо. Үнэхээр сонирхолтой сайхан юм. Та цаг авч заалгасан уу? Та үнэхээр өөрийн лимбийг хийсэн үү?

Нисэхүү: Тиймээ, би бага сургуулын 3-р ангид байхдаа хөгжим тоглож эхлэсэн маань хожим цэргийн хөгжимчин болоход нөлөөлсөн байх. Цэргийн албанд хөгжмийн салаанд байх хугацаандаа олон сайхан урлагийн хүмүүстэй хамт ажиллаж



байсан болохоор тэднээс их зүйл сурсан. Лимбийг би зүгээр сонирхлын үүднээс нэг удаа хийж үзсэн, дажгүй болсон шүү. Олон Улсын Тахь Группээс ГИДЦГ-ын захиргааны байшинг барьж байхад барилгын талбай дээрээс цахилгааны утасны хамгаалалтын хуванцар хоолойг нүхлэн лимбэ хийж манай энд зохион байгуулагдсан багахан хурлын хүлээн авалтын баяр дээр аялгуу тоглож үзүүлсэн нь хүмүүст таалагдсан бололтой.

ОУТГ: Таныг 1994 онд анх байгаль хамгаалагчаар ажиллаж эхэлснээс хойш танай ажлын орчин нөхцөлд их өөрчлөлт орсон уу?

Нисэхүү: Намайг ажиллаж эхэлхэд Тахийн талын нутагшуулах хашаанд цөөн хэдэн тахь байдаг байсан. Тэр үед тусгай хамгаалалттай газрын төв байр нь нэг л "вагончиг" байсан. Тухайн үед би тахь тээвэрлэх үйл явцад тэр бүр оролцдоггүй байв. Хамгаалалттай газрын баруун хэсэгт тахь авчирсан 2005 оноос миний ажил үүргийн хуваарь эрс өөрчлөгдсөн. Тахь хамгаалах миний хоёр дох ажил эхэлж, судлаачид, олон улсын эрдэм шинжилгээний багийнхантай хамтран ажиллах болсон. Мөн ГИДЦГ-ын "Б" бүсэд зэрлэг амьтдын тооллого мониторинг хийх ажилд гар бие оролцож, нутгийн баруун талын хэсэгт тооллогын зам чиглэлийг гаргаж байлаа. 1994 онд би ажилдаа мотоцикл ашигладаг байсан бол 2005 онд анхны УАЗ-469 машинаа хүлээн авч, өнөөг хүртэл ажилдаа автомашин ашиглах болсон. Сүүлд Тахийн усанд бид байгаль хамгаалагчдын байр, өвсний агуулах, автомашины граж барьж ашиглах болсноор говьд хоноглоход илүү тухтай нөхцөл бүрдүүлж өгсөн юм.

ОУТГ: Өнгөрсөн хугацаанд хэд хэдэн хүнд өвлүүд болсон. Энэ таны ажилд яаж нөлөөлсөн бэ?

Нисэхүү: Тийм, 1997/98 он, 2000/2001 он, 2009/2010 оны зуд¹ – наас болж их ажил гарсан. 2009/2010 оны зуданд би тахь байрлаж буй газар луу явж, өвс хүргэхээс гадна тахиудын байдлыг шалган төврүү мэдээлж байсан. Азаар баруун бүсэд байгаа тахийн сүрэг зуданд бага өртөж, тэр өвөл бид нэг тахь л алдсан. Бидний хүнд хэцүү үед тусалсан олон улсын тахь групп болон бусад дэмжигч хандивлагч нартаа маш их талархаж явдаг даа. Энэхүү тусламжийн ачаар тахийг аюулгүй байлгахад шаардлагатай зүйлсийг хурдан хугацаанд амжуулсан. Эдгээр хүнд өдрүүдэд бид тахийг хэрхэн арчлах, өвс тэжээлийг зохицуулах, ирээдүйд гарч ирэх хүндрэл бэрхшээлийг хэрхэн даван туулах тал дээр маш их зүйл сурсан. Бидэнд байнга тулгардаг асуудал бол мэдээж байгаль хамгаалагчдын унаа тэрэгний урсгал зардал, дэд бүтэц болон тоног төхөөрөмжийн санхүүжүүлтийн асуудал байдаг. Тэглээ гээд бид гараа хумхиад суудаггүй ээ. Учир нь бид сэтгэл зүрхээрээ ажилдаа ханддаг.

¹ Зуд = өвлийн хахир хүйтэнд олон сая мал үхэж үрэгдэх

ОУТГ: Тахийн талаар орон нутгийнхан ямар бодолтой байдаг вэ?

Нисэххүү: 2005 онд анх Тахийн усанд тахь авчрахад би сумын захиргаа, соёлын төв, эмнэлэг, сургууль, цэцэрлэгээр явж „Тахь эх нутагтаа, манай нутагт эргэж ирсэнд бид үнэхээр бахархах хэрэгтэй” гэж би хэлдэг байсан. Орон нутгийн иргэдийн ихэнх нь тахийг эерэгээр хүлээн авч, туслахыг хичээж ирсэн. Зарим нь тахь хараад унаганд нь нэр өгөхийг хүртэл надаас асуудаг байв. Тухайн үед орон нутгийн иргэдийг байгаль, ан амьтан хамгаалах ажилд татан оролцуулах зорилгоор тэдэнтэй хамт явж тахиудаа эргэж тойрдог байлаа. Мэдээж энэ нь надад болон манай байгууллагын унаа тэрэг, шатахууны зардалд хэмнэлт гардаг сайн талуудтай. Зарим нутгийн иргэд, ААН-үүд бидний үйл ажиллагаанд багагүй тусламж дэмжлэг үзүүлж ирснийг дурьдах хэрэгтэй байх. Жишээлбэл н.Цэрэнчимэд даргатай аудитын компани нэг тахинд „Аудит” хэмээн нэр өгч зохих хэмжээний дэмжлэг өгсөн, н.Гантулга даргатай Хөрс ХХК 2009/10 оны зуднаар тахинд өвс, тахь нутагшуулах төвд шатахууны нөөцийг хүргэх ачааны машин, түлшийг хандивлаж байсан нь бидний хувьд маш чухал, ач холбогдолтой дэмжлэг байсан.

ОУТГ: Тантай хамт ГИДЦГ-ын “Б” бүсэд явахаар бид хоосон тал харж байхад та тахь хаана байгааг маш сайн олж мэддэг. Энэ нь таны малчин байсантай холбоотой юу эсвэл та сурч авсан уу?

Нисэххүү: Хүн ажиллах явцдаа сурдаг юмаа. Яаж мэддэгээ танд би яг сайн тайлбарлаж чадахгүй нь ээ. Миний хийж буй ажлаасаа хуримтлуулсан 20 жилийн туршлага байхдаа. Эхний жилүүдэд бид тахиудын зан авирыг сайтар ажиглаж, ойлгож сурах хэрэгтэй байсан. Явцдаа таамаглаж байсан газарт байхгүй бол тэднийг хаанаас хайж болохыг мэддэг болсон. Зэрлэг адуу юуг мэдэрдэгийг ойлгохыг хичээх болсон. Энэ чадварыг олон малчин эзэмшсэн байдаг боловч. Гэхдээ малчидтай харьцуулахад бидэнд сайн тоног төхөөрөмж байна. Олон улсын тахь групп, Прагийн амьтны хүрээлэн болон Жиан Пийррэ, Соня Зийгфрийд сан зэрэг өгөөмөр хандивлагчдаас өгсөн өндөр хүчин чадалтай телескоп, автомашин, GPS зэрэг тоног төхөөрөмж бидэнд байна.

ОУТГ: “Б” бүсэд одоогоор 167 тахь байна. Эдгээрийн дунд таны хайртай тахь бий юу?

Нисэххүү: Өө тэгэлгүй яах вэ – Тахийн мэдээ сэтгүүлийн сүүлийн дугаарын нүүр хуудсанд гарсан байгаа! Тахийн усанд байгаа нэг сүргийн толгойлогч Зур нэртэй гүү юм. 2009/10 оны зуднаар хүйтэн өвлийг давахад зориулж тахинд өвс тэжээл өгөхөөр оролдож байсан юм. Цас ихтэй байсан тул бид тийм ч их дөхөж очиж чадахгүй байсан. Тэгэхээр нь би тэвэр дүүрэн өвс аваад аажмаар явган дөхөж очсон. Зур намайг ажиглаж байснаа аажмаар надруу дөхсөнөө холдоод байсан. Тэгэхээр нь би өвсөө харуулаад цасан дээр тавиад орхитол аажмаар дөхөж байгаад өвс идсэн. Толгойлогч гүү юу хийнэ бусад нь дагадаг юм. Тиймээс Зуртэй ойлголцох хэрэгтэй. Сүргээ өвлийн хүйтнийг давахад Зур надад их тусалсан. Би Зурийг миний хамгийн сайн хамтрагч гэж боддог!

ОУТГ: Та тахь болоод өөрийнхөө ирээдүйн төлөө юу хүсэж байна вэ?

Нисэххүү: Би тэтгэвэртээ гарахаараа ач, зээ нараа дагуулаад тал дундуур давхиж, байгалийн сайхныг харуулна гэж төсөөлдөг. Тэр үед ГИДЦГ-т зуу зуугаар, магадгүй мянган тахь яг л хулан шиг хөндлөн давхилдаж байна байх гэж төсөөлдөг. Тэр үед би: „Энэ гайхалтай зэрлэг адууг эх оронд нь эргэн нутагшуулахад би гар бие оролцож явсан” гэж хэлэн бахархаж байх болно!

Монголчуудын нэр их учир утгатай

Нисэххүүгийн ээж Ховдын алдарт дуучин байсан. Тэрээр Улаанбаатарт зохиогдсон тоглолтонд оролцоод буцаж явах замдаа түүнийг төрүүлсэн юм. Ховдын онгоцны буудалд газардахаас өмнөхөн Нисэххүү хүлээлгүй – онгоцонд мэндэлжээ. Тиймээс түүнд ийнхүү Нисэххүү нэр хайрлажээ. Тахийн тал дах түүний анд нөхөд түүнийг заримдаа „агаарын хүү” гэж нэрлэх нь ч бий.

Хамгаалахын тулд судлахуй

Бодит тоо, мэдээлэлгүй байгаль хамгаалах нь үр дүнгээ өгөхгүй. Дархан цаазат газрыг оновчтой зөв хамгаалах, удирдахад найдвартай тоо баримт, өргөн цар хүрээтэй, урт хугацааны хэтийн төлөв шаардлагатай байдаг. Гэвч олон шийдэгдээгүй асуудлууд байна. Нэн шаардлагатай байгаа асуудлаа хэлэлцэхээр Олон улсын тахь групп болон ГИДЦГ-ын “Б” бүсийн төлөөлөгчид, европ, монголын тахийн судалгааныхан энэ оны 2-р сарын сүүлээр Швейцарьт нэг өдрийн турш уулзалт хийж дараа жилүүдийн судалгааны төлөвлөгөөг гарган ярилцлаа. Судалгааны ажил нь Олон улсын тахь группын гол үүрэг болж байна.

Венийн Их Сургуулийн Мал эмнэлэгийн факультетийн зэрлэг ан амьтдын экологийн судалгааны хүрээлэнгийн Проф. Крис Вальцэр, Др. Петра Качценски нар сүүлийн 20 жилд тэдний хамт олон ямар мэдлэг, мэдээлэл цуглуулж, боловсруулсанаа танилцуулсан юм.

Үүний дараагаар оролцогчид өөрсдийн санаа бодлоо хэлэлцэн ойролцоогоор тавь гаруй судалгааны санаа дэвшүүлж, үүнээс хамгийн нэн тэргүүнд шаардлагатай байгаа асуудлыг сонгосон. Үүнд байгалийн уст цэгүүдийг ан амьтан хэрхэн ашиглаж, хэрэглэж байгааг тодорхойлох автомат камер ашиглан судлах, бараг судлагдаагүй байгаа хар сүүлт зээрийн экологи биологи, тахийн сүргийн генийн солилцоо, нийгэм, соёлын шилжилтийн үед байгаа орон нутгийн иргэдийн нийгэм эдийн засгийн судалгаа зэрэг болно.

Оролцогчид эцэстээ дараагийн жилүүдэд хэрэгжүүлэх 9 асуудлын төлөвлөгөөн дээр санал нэгдсэн. Ийнхүү хэлэлцүүлэг, санал солилцоо хийсэн боловч хэн, юу хариуцах, санхүүгийн эх сурвалж зэрэг төслийн нарийвчилсан асуудлуудыг дахин шийдвэрлэхээр болов.

Оролцогчид ГИДЦГ-ын “Б” бүсийн судалгааны ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зөвлөлдөх, удирдах зорилгоор Др. Петра Качценски-ийн удирдлаган дор Олон улсын Тахь Группын судалгааны зөвлөл буй болгохоор шийдсэн юм.



Судалгааны ажлын төлөвлөгөөг хэлэлцэж буй ажлын хэсэг.

Төрөл зүйл:

Сибирийн тарваганы тухайд түүний хувь заяа арван нэг тавин тав /11цаг:55минут/ болж байна.

Тахийн мэдээг уншдаг Швейцарь хэрэглэгчид тарвагыг альпийн нуруунд байдгаар нь мэднэ. Жуулчдын хөл хөдөлгөөнд дассан тарвагыг үйл хөдлөл, харагдах байдлаас нь болон зургийг нь жуулчид авах их дуртай байдаг.

Marmota sibirica –ын төрөл зүйл болох “монгол тарвага” нь Монголд элбэг тархалттай ба арай шаргал өнгөтэй. Тарвагыг хүмүүс Монголд хоол хүнсэнд ашиглахаас гадна арьсыг нь хэрэглэдэг. Тарваганы тоо толгой 10 жилийн дотор 70 гаруй хувиар буурсан ба хэдийгээр хамгаалалтад байгаа ч цаашид буурах хандлагатай байна. Тарвагыг хамгаалах дорвитой үйл ажиллагаа явуулаагүй учир Монгол болон сибирийн тарвага улаан номонд бичигдэх төрөл зүйл болоод байна.

Тоо хэмжээ хоргодох шалтгаан нь нууцаар, нарийвчилсан, холын зайн буугаар хулгайн ан хийж байгаагаас болж байна. Хуулийн дагуу агнах квот 3 дахин илүү давсан ба Монголд тарваганы махыг маш амтархан иддэг. Угтаа тарвагыг амьд байлгах нь махыг нь идснээс илүү эдийн засгийн хувьд үр ашигтай. Учир нь тарвагаар жуулчдыг татаж болох юм. Тарвага нь амьдарч буй тал нутаг, говь тал, уул усанд хэрэгтэй гол төрөл зүйл учир хулгайн ан хийх нь экологийн хувьд гамшиг юм. Тарвагыг устгах нь махчин амьтад болоод махчин шувуудын тоо хэмжээнд дам нөлөөлж буй хэрэг юм.

Өвс, ургамлаар хооллодог тарвага нь уул нуруу, тал нутагт нөлөө үзүүлж байдаг. 9-р сараас 4-р сар хүртэл гэр бүлээрээ ичээндээ ордог ба биеийн дулаан нь 5-6°C болж буурдаг байна. Гэвч хоёр долоо хоног тутамд бүгд үүрэндээ нэгэн зэрэг 36°C болтлоо биеэ дулаацуулдаг нь маш их эрчим хүч шаарддаг байна. Хэрэв нас бие гүйцээгүй залуу тарвага байвал эцэг эх болон ах, эгч нь 4°C -с илүү температурыг бий болгож, залуу бодгалиудыг голдоо оруулан дулаацуулдаг ажээ. Ингэж харилцан дулаацуулахгүй бол залуу тарвага тэсч амьд үлдэх боломжгүй юм. Иймд эцэг, эхийг нь хороосон бол тэр гэр бүлийг бүгдийг нь хороож буйтай адил юм.

Хулгайн ан зогсохгүй байгаа тохиолдолд амьтдыг хамгаалах тухай ярих, төлөвлөх нь нэлээд хэцүү ажил юм. Гол төрөл зүйл амьтад хоргодох, устаж үгүй болох нь нийт амьдрах орчин, түүний зохилдлогоог устгаж буй учир экосистем нь анхаарал татсан төлөөлөгчдөөс илүү чухал юм. Сибирийн тарвагыг нэн даруй судлах шаардлагатай ба орон нутгийн удирдлага агналтыг зогсоохоос гадна амьдарч буй орчинг нь хамгаалах шаардлагатай. Мөн сэлгүүлэн нутагшуулах, популяцийн нөхөн сэргэх нөхцлийг бүрдүүлэх зэрэг арга хэмжээг авах нь зүйтэй. Учир нь сибирийн тарваганы тухайд түний хувь заяа арван нэг тавин тав болж байна. Тахийг аврахаар хэн тэр үед цагаа харж байлаа?

¹ Батболд 2002, 2 Арнолд В, Хэлдмайер Г 1992



Сибирийн тарвага, голчлон Монголд тархсан ба бичиг баримтаар хамгаалагдсан боловч тоо хэмжээ нь 10 жилийн дотор 70%-иар буурсан. Аюулд өртөж буй ан амьтдыг бүртгэдэг улаан номын жагсаалтад орсон. ГИДЦГ-ын “Б” бүсэд байгаа тарвагыг байгаль хамгаалагч Алаа ажиглаж байна.



Тахийн талд багшлав: Олон улсын тахь группт сайн дурын ажил эрхлэсэн нь

Тэтгэвэрт гарсан швейцарь багш Ули Рүтц 2016 оны 5-р сарын 13-наас 6-р сарын 18-ныг хүртэл 4 долоо хоног Тахийн тал дахь тахь нутагшуулах төвийн ажилчид, байгаль хамгаалагч нарт болон хүүхдүүдэд англи хэл заажээ. Ийнхүү ажилласан нь хоёр талд мартагдахааргүй туршлага байлаа. Хэрхэн энэ ажлыг хийх болсноо тэрээр өөрөө тайлбарлана.

Ули Рүтц

Энэхүү ажил, аялал миний танил Anita Fahrni¹-гийн зөвлөснөөр эхэлсэн. Монголд жуулчлалаар бус англи хэл заахаар очиж шинэ зүйл харах, үзэх гэдэг нь содон байсан. Алс тал нутгийг үзэж харах, өөр зүйлд цагаа зориулах гэдэг нь тэтгэвэрт гарсны давуу тал байлаа. Тахийн талд очсон шалтгаан минь энэ байсан. Нуулгүй хэлэхэд түүнийг би сайн танихгүй ч яагаад ч юм үйл явдал өрнөсөн.

Монголд байсан хугацаа гайхалтай сайхан байсан. Ганбаа² болон түүний баг хамт олон надад анхаарал тавин найрсагаар хандаж байсан. Анх уулзаад л тэдэнд итгэсэн. Улаанбаатарт онгоцны буудлаас Сайханаа³ намайг тосч авсан ба Ховд хотод байгаль хамгаалагч, Алтай сумд Алтансүх⁴, Аги¹ Нанжид – тосч авсан. Ганбаагаас гадна англи хэлний хичээлд маш сайн сурагчид байсан шүү. Тэд надад зориулж тусгайлсан мэргэжлийн тогооч Тунгаагаар хоол хийлгэж байсан ба түүний бэлтгэсэн хоол болон миний амьдарч байсан гэр надад үнэхээр таалагдаж байсан.

Яагаад ч юм бэ тахь нутгагшуулах төвд англи хэлний хичээлээ явуулж эхлэх гэж нэлээд хугацаа өнгөрсөн юм. Гэсэн хэдий ч хичээлээ зааж эхлүүлсэний дараа байгаль хамгаалагчид миний хичээлд маш анхааралтай, их хичээл зүтгэлтэй оролцож байсан бөгөөд өдөрт нэлээд олон цагаар тэд суралцаж байв. Түүнээс гадна би Бугат сумын дунд сургуулийн сурагчдад хэдэн өдөр англи хэлний хичээл заах болсон юм. Цаг агаар нэлээд хүйтэн байсан ч сурагчидтай ажиллах цаг хугацаа надад халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлж байсныг би одоо хэр нь санадаг.

Байгаль хамгаалагчид намайг өдөр тутмын ажилдаа нь туслахыг зөвшөөрсөн бөгөөд тэдэнтэй хамт тахийн сүргүүдийг ажиглах, унага тоолж, хүйсийг нь тодорхойлох гэж оролдох зэрэг ажлуудыг гүйцэтгэдэг байлаа. Тэд өөрсдийн ажиглалт бүрийг маш нягт нямбай тэмдэглэдэг, ажилдаа хандаж буй хичээл зүтгэл, тэсвэр тэвчээр миний сэтгэлээс гардаггүй юм. Бид хээрийн ажиглалт хийснийхээ дараа олон удаа оройтож харьдаг байсан. Азарга, гүү байнга л хамгаалалтын бүсээс гарч явна. Нэг удаа бид нэг гүүг 10 км –ийн хол газраас буцааж авчирч байсан. Түүнээс гадна бас нэг гүүг хятадын хилийн ойролцоох адуун сүрэгт нийлсэн байхад нь уураглан барьж буцаан авчирч байлаа.

Тахийн ус гэдэг газар шинээр авчрах тахиудад зориулж дасгах хашаа барих нь нэлээд хүч хөдөлмөр шаардсан амаргүй ажил

1 Anita Fahrni, Олон улсын тахь группын УЗ гишүүн

2 О.Ганбаатар, ГИДЦГ-ын "Б" бүсийн захирал

3 Н.Энхсайхан, Намтар, Олон улсын тахь группын монгол дахь салбарын захирал

4 Н.Алтансүх, БО-ны улсын байцаагч

байсан. Байгаль хамгаалагчдын амьдрал их эгэл жирийн бөгөөд тэд халуун нар, маш их шумуул, хөх түрүү биднийг байж суухын аргагүй болгож байсан ч тэд шаргуу хамтарч, өөр хоорондоо хөгжилдөн ажиллаж чаддаг, шөнөдөө гал тогооны өрөө байрлаж буй сууцны дээвэр дээр төвөггүйхэн унтчихдаг хүмүүс. Тэдний амьдралыг үзэх үзэл манай орныхоос тэс өөр. Дугуй хагарах, шаварт суух, ажлын багаж хэрэгсэл эвдэрч, хэмхрэх зэрэг гэнэтийн зүйлс тэдний өөдрөг сэтгэл санаанд огт нөлөө үзүүлэхгүй. Амьдралын зөвхөн тодорхой хэсэг зүйлсийг төлөвлөж болдог гэдгийг мэддэгтээ юу эсвэл амьдралыг үзэх үзэл нь тэрүү? Хөтөлбөрт өөрчлөлт орох нь өдрийн хоолондоо цай уудагтай адил энгийн ойлгомжтой зүйл байдаг байсан.

Ганбаа надтай ярилцах цаг заримдаа гаргадаг байсан нь тэднийг хоорондоо ярихад нь ойлгохгүй миний хувьд чухал байсан. Монгол хэл их хэцүү хэл. Олон дуудлага авиаг ялгаж салгаж чадахгүй, үгс тасралтгүй мэт санагдаж, бичгээр үйлдсэн туслах материал надад байгаагүй. Миний хувьд монгол хэл сурах боломжгүй байсан юм. Харин байгаль хамгаалагчдын гэр бүлтэй танилцсан нь монголчууд их найрсаг хүмүүс гэж монголын талаар уншсан мэдээлэлтэй нийцэж байсан.

Тахийн тал дахь хүмүүсийн амьдрал их энгийн байсан ч тахийн усанд богино хугацаагаар байсан миний нөхцөл байдалтай харьцуулахад Тахийн төвийн байр маань бараг л гэртээ ирсэнтэй адил тухтай санагдсан. Зочлох, багшлах хугацаандаа би сэтгэл ханамж дүүрэн туршлага хуримтлуулсан.



Ули Рүтц (зогсож буй нь) англи хэлний хичээл заах үеэр.



Хашаа барих хүнд ажлын завсарлага-өдрийн хоолны үеэр

Таны тусламж бидэнд хэрэгтэй

Байгаль орчныг хамгаалах ажил нь тийм ч дуулиантай биш байдаг. Ялангуяа дадал болсон ар талын ажлыг амжилттай төсөл болгоход тийм ч амаргүй юм.

Тиймээс таны өгсөн тусламжаар хэр олон зүйлд өөрчлөлт авчрахыг та эндээс харна уу. Өгч буй хандив бүр бидэнд үнэ цэнэтэй ба нээлттэй хүлээн авах болно.



40 000 төгрөг

Хамгаалагчийн нэг өдрийн хөлс (цалин, материалын зардал)



120 000 төгрөг

Унааны шатахууны зардал.



200 000 төгрөг

Байгаль хамгаалагчдын машины засвар, сэлбэг.



300 000 төгрөг

Тахийн усанд гаргасан шинэ худагнаас хамгаалалтын газрын төвтэй холбох зардал.



500 000 төгрөг

Нутагшуулах хашааны эвдрэлийг засан сайжруулах зардал



1000000 төгрөг

Хулан, зээрийн сүргийг хамгаалахад чухал хувь нэмэр оруулах

Олон улсын тахь групп нь сайн дурын үндсэн дээр ажилладаг ба таны хандивласан төгрөг бүр тахь хамгаалахад зориулагдана.

"Тахийн нөхөд"-ийн гишүүн болох боломж байна.

- Хувь хүний татвар 100 000 төгрөг

- Оюутан, залууст зориулсан унага – гишүүний татвар 40 000 төгрөг

Хандивын данс

Худалдаа Хөгжлийн Банк

Дансны дугаар: 499114883 ам доллар
499248691 төгрөг

Олон Улсын Тахь Группын Монгол дахь товчоо
Байгаль Ордон
Улаанбаатар-38
Монгол улс

Эрхлэн гаргасан

Олон улсын тахь групп

Тахийн нөхөд

Цюрих Вилдниспарк сан

www.savethewildhorse.mn

И-мэйл: itgmon@gmail.com

Утас: 976-11-362064

976-11-8811 2031



ITG INTERNATIONAL TAKHI-GROUP

Байгаль орчинд ээлтэй цаасан дээр хэвлэв
(Novatech Satin halb matt FSC)

